

Евро-Азийн зарим улсын иргэдийн татварын хандлагын харьцуулсан судалгаа

A Comparative Study of the Tax Attitude in Some Eurasian countries

Л. Буяндулам¹

Хураангуй

Судлаачдын үзэж байгаагаар хувь хүний татварын хууль тогтоомж даган мөрдөх нь татварт хандах хандлагатай ихээхэн хамааралтай байдаг. Энэхүү ажлаар Европ тивийн 17, Ази тивийн 21 улсын иргэдийн татварт хандах хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийг харьцуулан судалсан. Европын улсуудад ихэнх хувьсагчид эерэг, Азийн улсуудад сөрөг нөлөөлөх хандлагатай байна. Иргэдийн засгийн газарт итгэх итгэл, орлого, боловсрол, хүйс зэрэг нь Ази болон Европ тивийн улсуудад чухал нөлөө үзүүлдэг. Иргэд эрх баригчдын үйл хэргийг хэр дэмждэг, татвар төлснийхөө хариуд нийгмийн бараа, бүтээгдэхүүний чанар, хүртээмжид сэтгэл ханамжтай байгаагаас шалтгаалан татварын хандлага чухал нөлөөтэй байна. Хүйс азийн улсуудад өндөр нөлөөлж байна. Нийгмийн нөлөө нь азийн орнуудад сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөр байна.

Түлхүүр үгс: татварын хуулийг хэрэгжүүлэх хандлага, нийгмийн нөлөө, засгийн газар

Abstract

According to researchers, compliance with individual tax laws is significantly related to attitudes towards taxes. In this work, the factors affecting the attitude towards taxes of citizens of 17 countries in Europe and 21 countries in Asia were compared. Most of the variables tend to have a positive effect on European countries and a negative effect on Asian countries. Confidence in government, income, education, and gender are important factors in Asian and European countries. Tax attitudes have an important effect on how much citizens support the actions of the authorities and how satisfied they are with the quality and availability of social goods and products in return for paying taxes. Gender is highly influential in Asian countries. Social influence is more likely to be negative in Asian countries.

Keywords: tax compliance attitudes, social influence, government

¹ ШУТИС-ын харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль, Санхүү, менежментийн тэнхим
E-mail: buyaka812@yahoo.com

Удиртгал

Аливаа хүн татварын хууль, тогтоомжийг хэр зэрэг даган мөрдөх нь түүний татварт хандах хандлагатай ихээхэн хамааралтай байдаг. Тухайлбал, татварын хууль тогтоомжийг шүүмжилж буй татвар төлөгчтэй харьцуулахад татварын хууль тогтоомжийг эерэгээр хүлээн зөвшөөрдөг татвар төлөгчийн татвар төлөх хандлага эерэг байдаг байна. Иймээс олон нийтийг татвараа шударгаар төлөх сэтгэхүйтэй болгохын тулд улс орон бүрийн татварын албад дунд, урт хугацааны стратегиудыг боловсруулан ажиллаж ирсэн.

Судлаачдын хувьд ч татвар төлөгчийн татвар төлөх хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох замаар татварын эерэг хандлагыг нэмэгдүүлэх боломжийн талаар судалгаа хийж, санал боловсруулсаар байна. 2000 оноос хойш албан бус статистик мэдээгээр зөвхөн англи хэл дээр хэвлэгдсэн 80 орчим судалгааны ажил байна. Улс орон бүрийн хөгжлийн түвшин, соёл, иргэдийн сэтгэлгээ, төрийн зүгээс хэрэгжүүлж буй бодлого, орлого зэргээс хамаарч татварын хандлага, түүнд нөлөөлөх хүчин зүйлс нь ялгаатай байна.

Энэхүү судалгааны ажил нь Европ болон Ази тивийн (цаашид Евро-Азийн гэх) зарим улсын иргэдийн татварын хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсийг харьцуулан судлах юм. Ингэхдээ дэлхийн улсуудын татварын хандлагын талаар хийсэн судалгааны ажлуудад задлан шинжлэх, нэгтгэх, системчилж дүгнэх, харьцуулах зэрэг аргуудыг хэрэглэсэн. Евро-Азийн улсуудын татварын хандлагыг харьцуулан судалснаар татварын хандлагын онол арга зүйг хөгжүүлэх, цаашдаа татвар төлөгчийн татварын хуулийг даган мөрдөх

түвшинд сайжруулах боломжийг олох ач холбогдолтой юм. Татвар төлөгчийн хуулийг даган мөрдөх хандлага, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар олон улсын хэмжээнд хийгдсэн судалгааны зарим ажлыг дурьдвал:

Ali, Fjeldstad, & Sjursen (2013) нар Африк тивийн Кени, Танзани, Уганда, Өмнөд Африк улсуудын хувьд татвараас зайлсхийх нь хүндрэлтэй, мөн төрийн үйлчилгээний чанарт сэтгэл хангалуун байдал татварын эерэг хандлагатай бол нийгмийн угсаатны бүлэгт шударга бус ханддаг байдал (Танзан, Өмнөд Африк), татварын тухай мэдлэггүй байдал, эрүүгийн гэмт хэргийн бүлэглэлд хэтэрхий их хөрөнгө зарцуулдаг байдал зэрэг нь нэлээд сөрөг хамааралтай байсан.

Berenson (2007) адилхан социалист гэгдэж байсан ОХУ, Польш улсуудын иргэдийн засгийн газартаа итгэх итгэл татварт хандах хандлагыг хэр ижил байгаа байдалд судалгаа хийсэн ба төдийлөн ижил биш, итгэл үнэмшил татварт хандах хандлагад нөлөөлдөг гэдэг нь Польш улсын хувьд батлагдсан. Үр дүнтэй засаглалыг бий болгоход иргэдийн итгэлийг олох ёстой, мөн татварын албад нь иргэдийн татварт хандах хандлагад эерэгээр нөлөөлөхийн тулд иргэдтэй хамтран ажиллаж, туслалцаа үзүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн.

Zeng (2014) татвар төлөгчийн татварын хуулийг даган мөрдөх хандлагад 3 хүчин зүйл голчлон нөлөөлнө гэж таамагласан. Үүнд: нэгдүгээрт, татварын хуулийн тогтолцоо буюу татварын хуулийн нарийн төвөгтэй, хоёрдмол утгатай байдал, шударга байдал; хоёрдугаарт, хуулийн хэрэгжилт буюу торгууль шийтгэл, хяналт шалгалт; гуравдугаарт, засгийн газрын

зардлын төрөл зэрэг юм. Харин үр дүн нь татварын тогтолцоо нилээд хүчтэй нөлөөлдөг мөн засгийн газрын зардлын төрөл буюу зарцуулалт бас их нөлөөлдөг бол татварын албаны хууль сахиулах, хөндлөнгийн хяналт, торгууль ногдуулах нь хүмүүсийн татварын тайлагнах үйл ажиллагаанд ноцтой нөлөөлдөггүй гэж үзсэн. Судалгаагаар мөн хүйс болон мэдүүлэг өгөх туршлагаас хамаарч өөр өөр байдаг нь тогтоогдсон. Судалгааны материалыг хувь хүний орлогын албан татварын мэдлэгтэй татвар төлөгч хэн гэдгийг мэддэг Канадын бизнесийн болон эдийн засгийн ангийн оюутнуудын хамт цуглуулсан байна.

Nikiema & Zahonogo (2017) нар татвар дайчлах түвшин багатай бүсийн нэг болох Африкийн сахарын цөлийн 29 улсын татвар төлөгчдийн зан төлвийг судалж үзсэн ба татварын албаны чадамж сул байгаа байдал нь татвар төлөх эерэг хандлагад сөргөөр нөлөөлдөг гэсэн ерөнхий дүгнэлтэд хүрсэн байна. Гэхдээ энэ үзэгдэл нь эдгээр улсуудад харилцан адилгүй байна. Мөн төрийн үйлчилгээний чанар, шударга бус байдал зэрэг нь татвар төлөх хандлагад ихээхэн нөлөөлдөг гэсэн үр дүнд хүрсэн байна.

Татвар төлөгчийн татварын хуулийг даган мөрдөх хандлага, түүнд нөлөөлөх хүчин зүйлс

Татварын хууль тогтоомж даган мөрдөх гэдэг нь татвар төлөгч өөрийн олж буй орлого, хөрөнгөд тохирох шаардлагатай бүх татварын тайланг мөрдөгдөж буй татварын хууль тогтоомжийн дагуу үнэн зөвөөр, зохих цаг хугацаанд нь хөтөлж, зөрчил гаргасан бол шүүхийн шийдвэрийн дагуу татварын хариуцлагыг бүрэн дүүрэн биелүүлдэг байх явдал юм (Roth, Scholtz, & Witte, 1989).

Татвар төлөгчийн хуулийг даган мөрдөх сэтгэл зүй нь түүний татварт хандах хандлагатай ихээхэн хамааралтай байдаг байна. Татвар төлөгчийн татварт хандах хандлага гэдэг нь татвар төлөгчийн татварын хуулийг даган мөрдөх эсвэл эс мөрдөх тухай татвар төлөгчийн хандлага юм.

Онолын хувьд татвар төлөх хандлагыг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. Татвар төлөх эерэг буюу татварын хуулийг даган мөрдөх хандлага,
2. Татвар төлөх сөрөг буюу татварын хуулийг даган мөрдөхгүй байх хандлага (Mowen, 1987).

Хэдийгээр татварын хууль тогтоомжуудад түүний хэрэгжилтэд нөлөөлж болзошгүй олон тооны хүчин зүйлүүдийг тодорхойлсон байдаг боловч олон улсын түвшинд хийгдсэн судалгаануудаас харахад иргэдийн татвар төлөх хандлагад (Torgler, 2007; Luttmmer & Singhal, 2014) зургаан бүлэг бүхий 15 хүчин зүйл голчлон нөлөөлдөг байна (Зураг 1).


Татвар төлөгчийн татварын хуулийг даган мөрдөх хандлагад нөлөөлж буй хүчин зүйлс нь улс орон бүрт харилцан адилгүй байна.

Евро-Азийн зарим улсын иргэдийн татварын хандлагын харьцуулсан судалгаа


Евро-Азийн орнуудын татварын хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсийг харьцуулан судлахдаа Европын 17 улс, Азийн 21 улсад хийгдсэн судалгааны ажлуудын үр дүнг авч харьцуулсан. Судалгаанд хамрагдсан 38 улсад нийтлэг 14 хувьсагчийг татварын хандлагад үзүүлж буй нөлөөг судлан харуулсан байдаг.

Европын улсуудын татварын хандлагад нөлөөлж буй хүчин зүйлс харилцан

Зураг 1. Татвар төлөгчдийн татвар төлөх хандлагад нөлөөлдөг нийтлэг хүчин зүйлс



Зураг 2. Европын зарим улсын татварын хандлагад нөлөө үзүүлдэг хувьсагчдын тоо




адилгүй ба зарим улсад 3 хүчин зүйлс нөлөөлж байхад зарим улсад 12 хувьсагч нөлөө үзүүлж байна (Зураг 2). Тухайлбал, Австри улсад боловсролын зэрэг, орлогын түвшин нь сөрөө нөлөө үзүүлж байхад гэрлэлтийн байдал, засгийн газарт итгэх итгэл, шударга байдал, шууд ардчилал, иргэдийн үндэсний бахархал гэсэн хувьсагчид нь татварын хандлагад эерэг нөлөө үзүүлдэг байна. Харин Исланд улсын хувьд хүйс, татварын хувь, татварын талаарх мэдлэг, шударга байдал нөлөө үзүүлдэг бол татварын хувь хэмжээ эерэг, нөгөө 3 нь сөрөг нөлөө үзүүлж байна. Итали улсад нилээн олон хувьсагч буюу 12 хувьсагч нөлөө үзүүлдэг бол 9 хувьсагч эерэг нөлөөлж байхад 1 хувьсагч сөрөг, боловсрол болон орлогын нөлөө нь

тодорхой бус байна.


Азийн улсуудын хувьд татварын хандлагад нөлөөлж буй хүчин зүйлс нь Европын орнуудтай харьцуулахад мэдэгдэхүйц цөөхөн байна (Зураг 3). Хятад улсын татварын хандлагад шударга байдал, соёлын хандлага эерэг нөлөө үзүүлж байсан бол нас, хүйс, боловсрол, гэрлэлтийн байдал нь загварт нөлөөгүй буюу ач холбогдолгүй гарсан. Европын болон Азийн улсуудын нөлөөлөх хүчин зүйлсийн хооронд онцгой ялгаа байхгүй боловч Европын улсуудад ихэнх хувьсагчид эерэг нөлөө үзүүлж байсан бол Азийн, ялангуяа хөгжлөөр доогуур улсуудад сөрөг эсвэл нөлөөлөхгүй байх хувьсагчид олон байна. Филиппин улсын

Зураг 3. Азийн зарим улсуудын татварын хандлагад нөлөө үзүүлдэг хувьсагчдын тоо



Эх сурвалж: Ма (2017)

Зураг 4. Евро-Азийн улсуудын татварын хандлагад нөлөө үзүүлдэг хувьсагчид




Эх сурвалж: Ма (2017)

хувьд орлого, илрэх магадлал, засгийн газарт итгэх итгэл, үндэсний бахархал гэсэн дөрвөн хувьсагч нөлөө үзүүлж байсны засгийн газарт итгэх итгэл, үндэсний бахархал нь эерэг, бусад нь сөрөг нөлөө үзүүлж байсан.

Иргэдийн засгийн газарт итгэх итгэл, орлого, боловсрол, хүйс зэрэг хувьсагчид Евро-Азийн улсуудад аль алинд нь нөлөө үзүүлэгч чухал хувьсагчид байна (Зураг 4). Иргэд ерөнхийлөгч, ерөнхий сайд,

засгийн газар болон эрх баригчдын үйл хэргийг хэр дэмждэг, татвар төлснийхөө хариуд нийгмийн бараа, бүтээгдэхүүн, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, гэмт хэрэг, терроризм, авилга гэх мэт гэмт үйлдлүүдийг илрүүлж буй байдал, тэдний эсрэг авч байгаа арга хэмжээнд хэр сэтгэл ханамжтай байгаагаас шалтгаалан татварын хандлагад чухал нөлөө үзүүлж байна. Хүйс нь Азийн улсуудад ихэвчлэн нөлөө үзүүлдэг бол

Зураг 5. Евро-Азийн зарим улсын татварын хандлагад нөлөөлж буй хүчин зүйлс



Европын улсуудад харьцангуй бага байгаа нь тэдгээр улсуудад хүйсийн ялгаатай байдал бага байдагтай холбоотойг Ма (2017) судалгааныхаа ажилд дурджээ. Тэрээр нийгмийн нөлөө нь хөгжиж байгаа орнуудад татварын хандлагад сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөртэй бол хөгжингүй орнуудад эерэг нөлөө үзүүлэх хандлагатайг харуулсан байдаг. Бидний судалгаанд хамрагдсан улсуудаас нийгмийн нөлөө нь Азийн хоёр улсад сөрөг нөлөө үзүүлж байсан бол Европын таван улсад эерэг нөлөөг үзүүлсэн. Энэ нь бидний харьцуулсан судалгаанд багтсан улсуудад Азийн хөгжиж буй улсууд олон байгаатай холбоотой байж болох юм.

Дээрх зургаас харахад судлагдсан 38 улсын хувьд иргэдийн засгийн газарт итгэх итгэл, шударга байдал, татварын мэдлэг, үндэсний бахархал, шууд ардчилал, соёлын хүчин зүйлүүд нь иргэдийн татварт хандах хандлагад эерэгээр нөлөөлдөг байна. Энэ нь ялангуяа Европын орнуудын хувьд маш их нөлөөтэй байдаг байна.

Дүгнэлт

Энэхүү ажлаар Европын 17 улс, Азийн 21 улсын иргэдийн татварт хандах хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийг харьцуулан судалж дүгнэлт хийлээ.

Европын улсуудын хувьд татварын хандлагад нөлөөлж буй хүчин зүйлс нь Азийн улсуудтай харьцуулахад мэдэгдэхүйц цөөхөн байна. Евро-Азийн улсуудын татварт хандах хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн хооронд онцгой ялгаа байхгүй боловч Европын улсуудад ихэнх хувьсагчид эерэг нөлөө үзүүлж байсан бол Азийн улсуудад сөрөг нөлөөлөх эсвэл нөлөөлөхгүй байх хувьсагчид олон байгаа нь анзаарагдлаа. Засгийн газарт итгэх итгэл, орлого, боловсрол, хүйс зэрэг хувьсагчид Евро-Азийн улсуудад нөлөө үзүүлж байдаг чухал хувьсагч болох нь харагдсан. Иргэд ерөнхийлөгч, ерөнхий сайд, засгийн газар болон эрх баригчдын үйл хэргийг хэрдэмждэг, татвар төлснийхөө хариуд нийгмийн бараа, бүтээгдэхүүн, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ,

гэмт хэрэг, терроризм, авилга гэх мэт гэмт үйлдлүүдийг илрүүлж буй байдал, тэдний эсрэг авч байгаа арга хэмжээнд хэр сэтгэл ханамжтай байгаагаас шалтгаалан татварын хандлагад чухал нөлөө үзүүлж байна. Хүйс нь Азийн улсуудад ихэвчлэн нөлөө үзүүлдэг бол Европын улсуудад харьцангуй бага байгаа нь Европын улсуудад хүйсийн ялгаатай байдал бага байдагтай холбоотой юм. Мөн нийгмийн нөлөө нь Азийн улсуудад татварын хандлагад сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөртэй бол Европын улсуудад эерэг нөлөө үзүүлэх хандлагатай байна.

Ашигласан материал

- Ali, M., Fjeldstad, O.-H., & Sjursen, I. H. (2013). *Factors Affecting Tax Compliant Attitude in Africa: Evidence from Kenya, Tanzania, Uganda and South Africa*. Centre for the Study of African Economies (CSAE) Conference. Oxford.
- Allingham, M. G. & Sandmo, A. (1972). Income Tax Evasion: A Theoretical Analysis. *Journal of Public Economics*, 1(3-4), 323-338.
- Alm, J., McClelland, G. H., & Schulze, W. D. (1992). Why Do People Pay Taxes? *Journal of Public Economics*, 48(1), 21-38.
- Andreoni, J., Erard, B., & Feinstein, J. (1998). Tax Compliance. *Journal of Economic Literature*, 36(2), 818-860.
- Becker, G. S. (1968). Crime and Punishment: An Economic Approach. *Journal of Political Economy*, 76(2), 169-217.
- Berenson, M. (2007). *Becoming Citizens: Attitudes Toward Tax Compliance in Poland, Russia and Ukraine*. Mimeo.
- Bodea, C. & LeBas, A. (2013). *The Origins of Social Contracts: Attitudes towards Taxation in Urban Nigeria* (CSAE Working Paper WPS/2013-02). Oxford: Centre for the Study of African Economies, University of Oxford.
- Cobham, A. (2005). *Tax Evasion, Tax Avoidance and Development Finance* (QEH Working Paper Series - QEHWPS129). Oxford: Finance and Trade Policy Research Centre, University of Oxford.
- Cowell, F. A. & Gordon, J. P. F. (1988). Unwillingness to Pay: Tax Evasion and Public Good Provision. *Journal of Public Economics* 36(3), 305-321.
- D'Arcy, M. (2011). *Why Do Citizens Assent to Pay Tax? Legitimacy, Taxation and the African State* (Afrobarometer Working Paper No. 126).
- Economist Intelligence Unit (2011). *The Democracy Index 2011: Democracy Under Stress*.
- Fauvelle-Aymar, C. (1999). The Political and Tax Capacity of Government in Developing Countries. *Kyklos*, 52(3), 391-413.

- Fjeldstad, O.-H. (2001). Taxation, Coercion and Donors: Local Government Tax Enforcement in Tanzania. *The Journal of Modern African Studies*, 39(2), 289-306.
- Fjeldstad, O.-H. & Semboja, J. (2001). Why People Pay Taxes: The Case of the Development Levy in Tanzania. *World Development*, 29(12), 2059-2074.
- Fuest, C. & Riedel, N. (2009). *Tax Evasion, Tax Avoidance and Tax Expenditures in Developing Countries: A Review of the Existing Literature* (Report Prepared for the UK Department for International Development). Oxford: Oxford University Centre for Business Taxation.
- Luttmer, E. F. P. & Singhal, M. (2014). Tax Morale. *Journal of Economic Perspectives*, 28(4), 149-168.
- Ma, J. (2017). *Taxpayers' Attitudes toward Tax Compliance in Developed and Developing Countries: A Critical Review of the Literature* [Masters Dissertation, Auckland University of Technology].
- Mowen, J. C. (1987). *Consumer Behavior*. University of Wisconsin, Macmillan.
- Nikiema, R. & Zahonogo, P. (2017). *Taxpayer Behaviour and Institutions in Sub-Saharan Africa* (BeFind Working Paper No19).
- Roth, J. A., Scholz, J. T., & Witte, A. D. (1989). *Taxpayer Compliance, Vol 1: An Agenda for Research*. University of Pennsylvania Press, Philadelphia.
- Torgler, B. (2007). *Tax Compliance and Tax Morale: A Theoretical and Empirical Analysis*. Edward Elgar Publishing Limited.
- Zeng, T. (2014). What Affects Tax Compliance Behaviour: A Survey Study. *International Proceedings of Economics Development and Research*, 69.